

## УНДНЫ УСНЫ ЧИГЛЭЛЭЭР ХИЙЖ ХЭРЭГЖҮҮЛСЭН АЖЛЫН ТАЙЛАН

2022 оны 12 дугаар сарын 25

Хатан суудал

Сумын хүн амын ундны эх үүсвэр болох Цагаан худаг, Цэргийн анги худгуудын усны дээжийн шинжилгээг 2022 оны 09 дүгээр сарын 04-ны өдөр Баянхонгор аймгийн Мэргэжлийн хяналтын газрын лабораторт өгч шинжлүүлсэн. Шинжилгээний хариугаар гэдэсний халдвартай байж болзошгүй гэсэн дүгнэлт гарсан. Уг дүгнэлтийн дагуу ариутгал халдваргүйжүүлэлтийг сумын эрүүл мэндийн төвөөр 2022 оны 09 дүгээр сарын 30, 10 дугаар сарын 01 ний өдрүүдэд хийж гүйцэтгэсэн. 2022 оны 10 дугаар сарын 05-ний өдөр давтан шинжилгээг явуулсан. 2023 онд 30 сая төгрөгөөр 2 худагт цэвэршүүлэх төхөөрөмж авахаар төсөвт суулгуулан ажиллаж байна.



Ундны эх үүсвэр болох цагаан худгийн тохижилтын ажлыг Засаг даргын тамгын газрын албан хаагч нар өөрсдийнхөө хөрөнгөөр засварласан мөн худгаас гарах илүүдэл усаар мод услах зорилгоор худгийн хажууд 10x10 хэмжээтэй тор татаж мод тарихаар төлөвлөсөн.



Хүн амын ундны усны эх үүсвэр болох Хатан суудал 5 дугаар багийн нутаг Харзтай гол орчмын цэвэрлэгээг Ц.Нацагдоржийн нэрэмжит ерөнхий боловсролын сургуулийн 10-12 ангийн 112 сурагчид, 18 багш ажилчид, Засаг даргын Тамгын газар гэсэн нийт 125 гаруй хүний бүрэлдэхүүнтэй 2022 оны 09 дүгээр сарын 07 ны өдөр 0,6 тонн бүхий хог хаягдлыг түүж цэвэрлэсэн .

